

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам (цаашид “журам” гэх)-ын зорилго нь Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмын эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай (Шинэчилсэн найруулга) хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж байна.

1.3.Энэ журмын үйлчлэлд төрийн цэргийн байгууллагууд, тагнуулын болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын алба хаагч хамаарна.

1.4.Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх), бүс нутгийн холбогдох бусад байгууллага, ажиллагаа явагдаж байгаа болон хамтран оролцох улс орны зүгээс энэ журамд зааснаас өөр тусгайлсан нөхцөл, шалгуурыг тавьсан тохиолдолд НҮБ-ын дүрэм, олон улсын гэрээний заалттай нийцүүлэн дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1.“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн” гэж Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 3.1.2-т заасныг ойлгоно.

2.2.“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн баг” гэж Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 3.1.3-т заасныг ойлгоно.

Гурав. Сонгон шалгаруулалтын хэлбэр, тавигдах шаардлага, шалгалтын төрөл

3.1.Энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалт нь дараах хэлбэртэй байна:

3.1.1.цэргийн алба хаагчийн;

3.1.1.1.удирдах албан тушаалтны;

3.1.1.2.штабын ажилтны;

3.1.1.3.цэргийн мэргэжилтний;

3.1.2.цэргийн багийн удирдлагын;

3.1.3.цэргийн багийн бие бүрэлдэхүүний.

3.2.Энхийг дэмжих ажиллагааны албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл, гүйцэтгэх үүргийн онцлогийг харгалзан энэхүү журмын 3.1.1, 3.1.2-т заасан цэргийн алба хаагч, цэргийн багийн удирдлага гэдэгт дараах албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг хамруулж ойлгоно:

3.2.1.энэ журмын 3.1.1.1-д заасан удирдах албан тушаалтанд цэргийн хүчний командлагч, командлагчийн орлогч, цэргийн хүчний командлалын штабын дарга, бүсийн командлагч, командлагчийн орлогч, НҮБ-ын төв штабын Энхийн ажиллагааны газар түүнтэй адилтгах нэгдсэн штабт удирдах албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг;

3.2.2.энэ журмын 3.1.1.2-т заасан штабын ажилтанд НҮБ-ын төв штабын Энхийн ажиллагааны газар болон түүнтэй адилтгах нэгдсэн штабт ажиллах штабын офицер, цэргийн хүчний болон бүсийн командлалын хэлтсийн дарга, бүсийн командлалын штабын дарга, штабын офицер, ахлагчийн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг;

3.2.3.энэ журмын 3.1.1.3-т заасан цэргийн мэргэжилтэнд цэргийн ажиглагч, цэргийн холбогч офицер, цэргийн ахлах зөвлөх, цэргийн зөвлөхийн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг;

3.2.4.энэ журмын 3.1.2-т заасан цэргийн багийн удирдлагад энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон Зэвсэгт хүчний батальон (рот, тусгай нэгж)-ы захирагч, захирагчийн орлогч, штабын дарга, батальон (рот, тусгай нэгж)-ы ахлагч нарыг;

3.2.5.энэ журмын 3.1.3.-т заасан цэргийн багийн бүрэлдэхүүнд энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон төрийн цэргийн байгууллага, тагнуулын болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын офицер, ахлагч, цэргийн гэрээт албаны түрүүч, байлдагч болон тусгай нарийн мэргэжлийн цэргийн гэрээт алба хаагчийг.

3.3.Энэ журмын 3.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч, цэргийн багийн бие бүрэлдэхүүнд дараах нийтлэг шаардлага тавигдана:

3.3.1.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь хэсэгт заасан нийтлэг үүрэг, Цэргийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлт болон төрийн албан хаагчийн болон цэргийн алба хаагчийн ёс зүйн шаардлагыг хангасан, цэргийн хэргийн зохих шатны мэдлэгтэй, мэргэжлийн болон багаар ажиллах ур чадвартай байх;

3.3.2.албан тушаалын үүргийн биелэлт, цэргийн сахилга, сургалт бэлтгэлийн дүнгээр “Сайн”-аас доошгүй үнэлэгдсэн байх;

3.3.3.цэргийн эмнэлгийн комиссын үзлэгээр биеийн эрүүл мэндээр тэнцсэн байх;

3.3.4.хамт олны дунд нэр хүндтэй, зан харьцаа, ёс суртахууны хувьд төлөвшсөн, сүүлийн нэг жилийн хугацаанд захиргааны, ёс зүйн болон сахилгын зөрчил гаргаагүй байх;

3.3.5.болзошгүй цагийн байдал, эрсдэлийг үнэлэх, түүнийг даван туулах бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилттэй байх;

3.3.6.цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдаж, цэргийн тангараг өргөсөн, цэргийн цолтой байх.

3.4.Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай байна.

3.5.Энэ журмын 3.1.1.2, 3.1.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь НҮБ-ын холбогдох сургалт, дамжааг дүүргэж, сертификат эзэмшсэн байна.

3.6.Энэ журмын 3.1.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчид дараах тусгай шаардлага тавигдана:

3.6.1. энэ журмын 3.2.1-т заасан албан тушаалд үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 20-оос дээш жил цэргийн алба хаасан, хурандаа түүнээс дээш цэргийн цолтой, команд, штаб, стратеги-тактикийн мэргэжилтэй англи хэлний түвшин тогтоох шалгалтад 85-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд энэ журмын 3.6.2-т заасан аль нэг албан тушаалд үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах, нэгдсэн штабт ажиллах, англи хэлээр баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.2.энэ журмын 3.2.2-т заасан цэргийн хүчний командлалын хэлтсийн дарга, бүсийн командлалын штабын дарга, штабын ахлах офицероор үүрэг гүйцэтгэхээр штабын ажилтны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 16-аас дээш жил цэргийн алба хаасан, дэд хурандаа, хурандаа цэргийн цолтой, стратеги, тактик, команд штабын мэргэжилтэй, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 80-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд цэргийн мэргэжилтэн эсхүл штабын офицероор үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, нэгдсэн штабт ажиллах, англи хэлээр штабын төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.3.энэ журмын 3.2.2-т заасан штабын офицероор үүрэг гүйцэтгэхээр штабын ажилтны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 10-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахмадаас дэд хурандаа цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 75-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд цэргийн мэргэжилтнээр үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, англи хэлээр штабын төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.4.энэ журмын 3.2.2-т заасан штабын ахлагчаар үүрэг гүйцэтгэхээр штабын ажилтны сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 10-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахлах ахлагч түүнээс дээш цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 75-аас дээш оноо авсан, энхийг дэмжих ажиллагаанд 2-оос доошгүй удаа үүрэг гүйцэтгэсэн, албан хэрэг хөтлөх, англи хэлээр баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай байх;

3.6.5.энэ журмын 3.2.3-т заасан цэргийн мэргэжилтний сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 10-аас доошгүй жил цэргийн алба

хаасан, ахмад, хошууч, дэд хурандаа цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 75-аас дээш оноо авсан, англи хэлээр хэлэлцээр хийх, баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай, радио холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, байршил тогтоогчийг ашиглах чадвартай, энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, 5-аас доошгүй жил тээврийн хэрэгсэл жолоодсон, механик хурдны хайрцагтай автомашин /4x4/-ыг жолоодох ур чадвартай, техник хэрэгсэлд өдөр тутмын техникийн үйлчилгээг бие даан хийх дадлага, туршлагатай байх;

3.6.6.энэ журмын 3.2.3-т заасан цэргийн ахлах зөвлөх, цэргийн зөвлөхөөр үүрэг гүйцэтгэхээр цэргийн мэргэжилтний сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 15-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахлах офицерын цэргийн цолтой, англи хэлний түвшин тогтоох шалгалтад 80-аас дээш оноо авсан, нэгдсэн штабт ажиллах, англи хэлээр төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах болон ярианы чадвартай, радио холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, байршил тогтоогчийг ашиглах чадвартай, энхийг дэмжих ажиллагаанд цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн туршлагатай, 5-аас доошгүй жил тээврийн хэрэгсэл жолоодсон, механик хурдны хайрцагтай автомашин (4x4)-ыг жолоодох ур чадвартай, техник хэрэгсэлд өдөр тутмын техникийн үйлчилгээг бие даан хийх дадлага, туршлагатай байх.

3.7.Энэ журмын 3.1.1-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь энэ журмын 3.3-т заасан нийтлэг шаардлага, энэ журмын 3.6-д заасан тусгай шаардлагаас гадна НҮБ, бүс нутгийн бусад холбогдох байгууллага, ажиллагаа явагдаж байгаа болон хамтран оролцох улс орны зүгээс тавьсан шаардлагыг хангасан байна.

3.8.Энэ журмын 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчид дараах тусгай шаардлага тавигдана:

3.8.1.энэ журмын 3.2.4-т заасан батальоны захирагчаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 20-оос дээш жил цэргийн алба хаасан, дэд хурандаа, хурандаа цэргийн цолтой, стратеги, тактик, команд-штабын мэргэжилтэй, англи хэлний ахисан дунд түвшний мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.2.энэ журмын 3.2.5-д заасан ротын захирагчаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 15-аас доошгүй жил цэргийн алба хаасан, хошууч, дэд хурандаа цэргийн цолтой, командын офицер мэргэжилтэй, гадаад хэлний ахисан дунд түвшний мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.3.энэ журмын 3.2.5-д заасан тусгай нэгжийн захирагч (дарга)-аар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 15-аас доошгүй жил цэргийн алба хаасан, ахлах офицерын цэргийн цолтой, тухайн чиглэлийн мэргэжлийн сургууль төгссөн, командын офицер мэргэжилтэй, гадаад хэлний ахисан дунд түвшний мэдлэгтэй, удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах чадвартай байх;

3.8.4.энэ журмын 3.2.5-д заасан батальон (рот, тусгай нэгж)-ы захирагчийн орлогч, штабын даргаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 15-аас дээш жил цэргийн алба хаасан, хошууч, дэд

хурандаа цэргийн цолтой, оператив-тактик, командын офицер мэргэжилтэй, гадаад хэлний дунд түвшний мэдлэгтэй, штабын ажлын туршлагатай, цэргийн албыг удирдан зохион байгуулах чадвартай байх;

3.8.5.Энэ журмын 3.2.5-д заасан батальон (рот, тусгай нэгж)-ы ахлагчаар үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь 10-аас дээш жил цэргийн алба хаасан, ахлах ахлагч, түүнээс дээш цэргийн цолтой, ахлагчийн ахисан түвшний сургалт, дамжааг төгссөн, гадаад хэлний дунд түвшний мэдлэгтэй, даргалах ахлагчийн албан тушаалд ажилласан туршлагатай, цэргийн албыг зохион байгуулах чадвартай байх.

3.9.Энэ журмын 3.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцох алба хаагчийн насыг тогтоохдоо Цэргийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 10.6 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5, 11.7 дахь хэсэгт заасныг баримтална.

3.10.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн багийн гүйцэтгэх үүргийн онцлогийг харгалзан цэргийн багийн бие бүрэлдэхүүнд тавигдах нэмэлт шаардлагыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага (цаашид “ЗХЖШ” гэх) тогтооно.

3.11.Энэ журмын 3.1-д заасан сонгон шалгаруулалтыг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон байнгын комисс зохион байгуулна.

3.12.Энэ журмын 3.1.1.1, 3.1.2 болон 3.2.2-т заасан удирдах болон штабын ажилтны сонгон шалгаруулалтын комисст БХЯ-ны төлөөллийг оролцуулна.

3.13.Сонгон шалгаруулалтын байнгын комиссын шийдвэрээр цэргийн багийн захирагч, удирдлагад үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчдыг урьдчилан сонгон шалгаруулж болно.

3.14.Энэ журмын 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг нэг нэгтгэл, ангийн тасаг, салаа, ротоор бүрдүүлэх бодлогыг баримтална.

3.15.ЗХЖШ-аас тогтоосон хяналтын тооны дагуу төрийн цэргийн байгууллага, тагнуулын болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас ирүүлсэн алба хаагчийг энэ журмын 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцуулж болно.

3.16.НҮБ-аас ирүүлсэн албан тушаалын шаардлага, хүсэлтийг харгалзан цэргийн багт үүрэг гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай тусгай мэргэжлийн албан тушаалд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг зөвхөн сонгон шалгаруулалтын байнгын комиссын шийдвэрээр сонгон шалгаруулна.

3.17.НҮБ-аас ирүүлсэн албан тушаалын шаардлагын улмаас энэ журмын 3.4-т заасан тусгай шаардлагыг хангаагүй боловч энэ журмын 3.3-т заасан нийтлэг шаардлагыг хангасан, зэвсэгт хүчинд 15-аас дээш жил цэргийн алба хаасан офицер, ахлагчийг өөрийн хүсэлт, нэгтгэл, анги, байгууллагын тодорхойлолтыг үндэслэн энэ журмын 3.1.1.2, 3.1.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцуулж болно.

3.18.Энэ журмын 3.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагч нь энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтын цахим бүртгэлийн

систем (цаашид “систем” гэх)-д бүртгүүлнэ. Цахим бүртгэлийн системийг ашиглах зааврыг ЗХЖШ-ын дарга батална.

3.19.Системийн шалгуурыг хангасан **сонгон шалгаруулалтад оролцох** цэргийн алба хаагчаас дараах төрлийн шалгалтыг авна.

3.19.1.биеийн тамирын бэлтгэл;

3.19.2.гадаад хэлний бэлтгэл;

3.19.3.замын хөдөлгөөний дүрэм, жолоодлогын дадлага;

3.19.4.мэргэжлийн ур чадвар;

3.19.5.хууль, эрх зүйн бэлтгэл;

3.19.6.сэтгэл зүйн сорил.

3.20.Энэ журмын 3.19.1-д заасан шалгалтыг “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын дагуу зохион байгуулж, шалгаж үнэлэх ба **алба хаагч нь** харьяа нэгтгэл, ангийн сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтын биеийн тамирын бэлтгэлжилтээр 70-аас дээш оноогоор дүгнэгдсэн байна. Байнгын комисс бие бүрэлдэхүүний 50-иас дээш хувьд хяналтын шалгалтыг авч болно.

3.21.Энэ журмын 3.19.2-т заасан шалгалтыг англи хэлний (ALCPT), шаардлагатай тохиолдолд бусад гадаад хэлний түвшинг тогтоох зорилгоор зохион байгуулж, унших, ярих, сонсох болон бичих чадвараар шалгаж үнэлнэ.

3.22.Энэ журмын 3.19.3-т заасан шалгалтаар замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг тестийн аргаар, тэнцсэн тохиолдолд механик хурдны хайрцагтай автомашин (4х4)-ыг жолоодох ур чадварыг автодром дээр болон замын хөдөлгөөнд оролцуулах байдлаар шалгаж үнэлнэ.

3.23.Энэ журмын 3.19.4-т заасан шалгалтаар радио болон сансрын холбооны хэрэгсэл, байрлал тогтоогчийг ажилд бэлтгэх, ажиллуулах, компьютерын өргөн хэрэглээний программыг ашиглан ажиллагааны баримт бичиг боловсруулах ур чадварыг дадлагаар, болзошгүй цагийн байдлыг үнэлж, шийдвэр гаргах ур чадварын дасгал боловсруулах аргаар шалгаж үнэлнэ.

3.24.Энэ журмын 3.19.5-д заасан шалгалтаар Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, Зэвсэгт мөргөлдөөний хууль, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, энхийг дэмжих ажиллагааны эрх зүйн баримт бичгийн мэдлэгийн төвшнийг тогтоох зорилгоор тестийн аргаар зохион байгуулж, шалгаж үнэлнэ.

3.25.Энэ журмын 3.19.6-д заасан сорилоор цэргийн алба хаагчийн анхаарал, ой тогтоолт, сэтгэн бодох чадвар зэрэг танин мэдэхүйн үйл явц, бие хүний сэтгэл зүйн онцлог шинж, сэтгэл хөдлөл, зан төлөвийн байдлыг сэтгэл зүйн стандарт тестээр авч, тодорхойлно.

3.26.Энэ журмын 3.1.1.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас НҮБ болон бүс нутгийн холбогдох байгууллагаас тавьсан шалгуур

үзүүлэлтийг удирдлага болгон энэ журмын 3.19.2, 3.19.5-д заасан шалгалтыг авна.

3.27.Энэ журмын 3.1.1.2, 3.1.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас энэ журмын 3.19-д заасан шалгалтыг авна.

3.28.Энэ журмын 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас 3.19.1, 3.19.2, 3.19.4, 3.19.5, 3.19.6-д заасан, энэ журмын 3.1.3-т заасан сонгон шалгаруулалтад оролцох цэргийн алба хаагчаас 3.19.1, 3.19.6-д заасан шалгалтыг тус тус авна. Шаардлагатай гэж үзвэл тусгай мэргэжилтэй алба хаагчаас ур чадварын нэмэлт шалгалтыг авч болно.

3.29.Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах тусгай нэгжийг сонгон шалгаруулахад энэ журмын 4.1.2-т заасныг хэрэглэхгүй байж болно.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

4.1.Энэ журмын 3.1-д заасан сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна:

4.1.1.нэгтгэл, анги, байгууллагын хүний нөөц хариуцсан албан тушаалтан системд алба хаагчийн мэдээллийг урьдчилж бүртгэсэн байх;

4.1.2.ЗХЖШ энэ журмын 3.1.1.2, 3.1.1.3-т заасан сонгон шалгаруулалтыг www.psod.maf.gov.mn, “Соёмбо” сонин болон БХЯ, ЗХЖШ-ын вэб сайт <https://www.mod.gov.mn/>; <https://www.gsmaf.gov.mn/gsmaf/-aap> нээлттэй зарлах;

4.1.3.сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан цэргийн алба хаагч нь өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн үзлэгт урьдчилан хамрагдаж, эрүүл мэндийн дүгнэлт гаргуулсан байх ба анги байгууллагын эмчээр үзлэгийн дүнг баталгаажуулсан дүгнэлт гаргуулсан байх;

4.1.4.энхийг сахиулах ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргаж буй цэргийн алба хаагч сонгон шалгаруулалтын системд дараах материалыг бүрдүүлж цахим хэлбэрээр байршуулна:

4.1.4.1.офицер, ахлагч (цэргийн гэрээт алба хаагч)-ийн үнэмлэхийн хуулбар (цол, албан тушаалд томилогдсон хуудасны хамт);

4.1.4.2.сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4х6 см-ийн хэмжээтэй цээж зураг 3 хувь;

4.1.4.3.иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолт;

4.1.4.4.иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт;

4.1.4.5.гадаад паспортын хуулбар (хүчинтэй хугацаа 3-аас дээш жил);

4.1.4.6.энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргасан ар гэрийн баталгаа;

4.1.4.7.алба хаагчийн ажил байдлын тодорхойлолт.

4.2. Сонгон шалгаруулалтад оролцох алба хаагч нь гүйцэтгэх албан тушаалын үүргийн онцлогоос шалтгаалан жолооны үнэмлэх, мэргэжлийн дамжаа төгссөн сертификатын хуулбарыг нэмэлтээр бүрдүүлсэн байна.

4.3. Алба хаагчийн төгсөлтийн шалгалтын дүнг нэгтгэл, анги, байгууллагын хүний нөөц хариуцсан албан тушаалтан системд оруулна.

4.4. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг ЗХЖШ-ын Эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгж, Цэргийн төв эмнэлэгтэй хамтран зохион байгуулна.

4.5. Энэ журмын 3.1-д заасан сонгон шалгаруулалтад орох алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-д заасны дагуу цэргийн эмнэлгийн комисс тодорхойлж, дүгнэлт гаргана.

4.6. Цэргийн төв эмнэлгийн дүгнэлтээр тэнцсэн хүсэлт гаргагчийн биеийн тамирын шалгалтыг ЗХЖШ-ын Биеийн тамирын асуудал хариуцсан нэгжийн боловсруулсан төлөвлөгөөний дагуу Сонгон шалгаруулалтын байнгын комисс зохион байгуулна.

4.7. ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн цэргийн командлал, удирдах газар нь албан ажлын болон бусад шаардлагаар цэргийн алба хаагчийг сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзсан тухай саналаа Сонгон шалгаруулах байнгын комисст цэргийн багийн ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэл эхлэхээс өмнө албан бичгээр ирүүлнэ.

4.8. Тухайн хасагдсан алба хаагчийг дараагийн удаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх сонгон шалгаруулалтад оролцуулах боломжоор хангахыг ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн цэргийн командлал, удирдах газар хариуцна.

4.9. Сонгон шалгаруулалтад тэнцсэн цэргийн алба хаагч, цэргийн багийн бүрэлдэхүүнийг ЗХЖШ-ын даргын тушаалаар ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлд хамруулна.

4.10. Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад тэнцсэн бүрэлдэхүүнийг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн нэгж танилцуулна.

4.11. Энэ журмын 3.1.1-т заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар дэмжигдсэн бүрэлдэхүүний холбогдох материалыг яамны Гадаад хамтын ажиллагаа хариуцсан нэгж, 3.1.2, 3.1.3-т заасан бүрэлдэхүүний холбогдох материалыг ЗХЖШ-ын Энхийг дэмжих ажиллагаа хариуцсан нэгж тус тус хариуцан Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт илгээнэ.

4.12. Энэ журмын 3.11-т заасан комисс 3.1.3-т заасан энхийг дэмжих ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлд бүрэн хамрагдсан цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, томилуулах саналыг Батлан хамгаалах яаманд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

4.13.Энэ журмын 3.2.1-д заасан НҮБ-ын Энхийн ажиллагааны алба, нэгжийн дарга, нэгдсэн штабын ажилтан, удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагч нь ЗХЖШ-ын даргын болон БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр сонгон шалгаруулалтад оролцоно.

Тав. Бусад зүйл

5.1.Цэргийн зохих шатны сургууль, дамжаа төгссөн, цэргийн жинхэнэ болон цэргийн гэрээт албанд элссэн, тухайн албан тушаалд өөр анги, байгууллагаас шинээр болон сэлгэн эсхүл шилжин томилогдсон офицер, ахлагчийн анхны цол авсан өдрөөс хойш 12 сараас доошгүй хугацаагаар алба хаасан офицер, ахлагч, цэргийн гэрээт албаны түрүүч, байлдагч энхийг дэмжих ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ гаргаж болно.

5.2.Цэргийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд өмнө нь 6 сарын хугацаагаар үүрэг гүйцэтгэсэн бол 12 сар, 12 сарын хугацаагаар үүрэг гүйцэтгэсэн бол 24 сарын дараа энэ журмын 3.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргаж болно. Энэ хугацааг үүрэг гүйцэтгэх хугацаа дуусгавар болсон өдрөөр тооцно.

5.3.Цэргийн алба хаагч штабын ажилтан, цэргийн мэргэжилтнээр үүрэг гүйцэтгэж ирсэн өдрөөс хойш 24 сарын дараа энэ журмын 3.1.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргаж болно.

5.4.Алба хаагчийг дараах тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй:

5.4.1.системд цахим шуудангийн хаягаа огт бүртгүүлээгүй болон ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хүсэлт гаргаагүй;

5.4.2.эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаагүй;

5.4.3.сонгон шалгаруулалтын явцад ёс зүйн, сахилгын зөрчил гаргасан болон гэмт хэрэг, зөрчилд холбогдож эрх бүхий байгууллагад шалгагдаж байгаа;

5.4.4.энэ журмын 5.1, 5.2-т заасан хугацааг баримтлаагүй бол;

5.4.5.батлан хамгаалахын болон бусад их, дээд сургууль, коллежийн өдрийн ангийн сургалт, дамжаа, гадаад хэлний дамжаанд суралцаж байгаа;

5.4.6.Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Цэргийн сахилгын дүрэм”, “Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-д заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй;

5.4.7.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонгон шалгаруулалтын нэгдсэн ажиллагаанд 3-аас дээш удаа хоцорсон.

5.5.Сонгон шалгаруулах байнгын комиссын шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл сонгон шалгаруулалтад оролцогч нь өргөдөл, гомдлыг Сонгон шалгаруулах байнгын комиссын даргад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гаргана.

5.6.Энэ журмын 5.5-д заасан комисс нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15, 16 дугаар

зүйлд заасны дагуу өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үндэслэл бүхий хариу өгнө.

5.7.Өргөдөл, гомдол гаргагч нь өргөдөл, гомдлын талаарх Сонгон шалгаруулах байнгын комиссын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд ЗХЖШ-ын даргад гомдол гаргах эрхтэй.

5.8.Өргөдөл, гомдол гаргагч цэргийн алба хаагч нь өргөдөл, гомдлыг энэ журмын 5.5, 5.7-д заасан комисс, эрх бүхий албан тушаалтанд шат дараалан гаргах үүрэгтэй.

5.9.Өргөдөл, гомдол гаргагч цэргийн алба хаагч нь энэхүү журмын 5.8-д заасан дарааллыг баримтлаагүй тохиолдолд ЗХЖШ-ын дарга өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэхээс татгалзах эрхтэй.

5.10.Энэхүү журмын 5.8 дахь заалтыг зөрчиж, өргөдөл, гомдол гаргасан алба хаагчийг Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Цэргийн албаны тухай хууль, “Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-д тус тус заасны дагуу захирах, захирагдах зарчмыг баримтлаагүй гэж үзэн сахилгын, ёс зүйн зөрчил гаргасанд тооцож, холбогдох хариуцлагыг хүлээлгэнэ.

5.11.Сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой аливаа маргаантай асуудлыг Сонгон шалгаруулах байнгын комиссын хурлаар тухай бүр хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.12.Өргөдөл, гомдол гаргагч нь энэ журмын 5.7-д заасан эрх бүхий албан тушаалтны хариуг үндэслэлгүй гэж үзвэл Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өргөдөл, гомдол гаргаж болно.

5.13.Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ОО---